



БАТЛАВ.

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН
ЗАХИРАЛ

Г.СҮГЛЭГМАА

БАТЛАВ.

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ
НИЙГЭМЛЭГИЙН ЗАХИРАЛ Н.ОЮУНЦЭЦЭГ



1138944 д. 8118477

**“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ”
СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
II БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ**

Танилцуулга:

БШУЯ болон Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ЖАЙКА)-тэй хамтран 2006-2013 онд “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх нь” хоёр үе шаттай хэрэгжүүлсэн төслийн үр дүнд 23 сургуулийн 2779 багш хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүй, технологийн нэг болох хичээлийн судалгааны арга зүйг эзэмшсэн байна. Хичээлийн судалгааны арга зүй нь Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, 2012-2016 онд хэрэгжих “Багшийн хөгжил” хөтөлбөрт дэвшүүлсэн “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга барилтай багшийг төлөвшиүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх гол арга замын нэг гэж үзсэн тул Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг хамтран 2013 онданхудугаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан билээ. Энэхүү хурлаар багш нарын бүтээсэн шилдэг арга туршлага, технологи, үр дүнг хэлэлцсэн нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг боловсронгуй болгон хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох нэг арга хэрэгсэл боллоо. Энэ нь багш нар ажлын байрандаа хамтдаа тасралтгүй хөгжих хэрэгцээ, сургуульд сууринласан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих бодлого, үзэл баримтлалд нийцэж байна. Ийм учраас эрдэм шинжилгээний хурал нь уралдаан, өрсөлдөөн бус хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн асуудлаар харилцан туршлага солилцох, тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцэх, нэгэн шийдэлд хүрэх талбар гэж үзэж байна.

НЭГ. ХУРЛЫН ЗОРИЛГО

Эрдэм шинжилгээний хурлын зорилго нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүй технологийн нэг - хичээлийн судалгааны менежмент, төрөл, арга хэлбэрийг өөрийн сургуульд хэрэгжүүлсэн арга туршлага, үр дүн, ололт амжилт, шийдлийн талаар хэлэлцэж туршлага солилцоход оршино.

“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ” сэдэвтэрдэм шинжилгээний хоёрдугаар бага хурлыг 2014 оны 12 дугаар сарын 17-18-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулна.

ХОЁР. ОРОЛЦОГЧИД

1. Бүх мэргэжлийн багш нар /аман илтгэл - Хичээл тус бүрээс гурван илтгэл /

2. Мэргэжлийн баг, багийн гишүүд, судлаачид /аман ба ханын илтгэл/
3. Сургуулийн удирдлага /аман илтгэл/
4. Багш мэргэжлээр их дээд сургуульд суралцаж байгаа оюутнууд /Ханын илтгэл/

ГУРАВ. ИЛТГЭЛ ХҮЛЭЭЖ АВАХ, ХЭЛЭЛЦЭХ

Илтгэлийг 2014 оны 11 дүгээр сарын30-ны өдрийн ажлын цагт багтаан файл хэлбэрээр hicheeliin.sudalgaard2014@gmail.com хаягаар болон БМДИ-ийн 702 тоот /арга зүйч Ж.Энэбиш /-д хүлээн авна.

Илтгэлийг хоёр үе шаттай хэлэлцэнэ.

1-р үе шат: Илтгэлийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг” болон “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх” мэргэжлийн багийн гишүүдээс бүрдсэн комисс уншиж, эрдэм шинжилгээний хуралд амаар илтгэх 2-3 илтгэл болон ханаар илтгэх илтгэлийг хэлэлцэж тогтоно.

2-р үе шат: 2014 оны 12 сарын 17-18-ны өдөр болох эрдэм шинжилгээний бага хуралд хичээл бүрээр 2-3 илтгэл хэлэлцүүлнэ. Ханын илтгэлийг олон нийтэд хэвлэмэл байдлаар дэлгэн үзүүлнэ. Эдгээр илтгэлүүдээс хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлахуйн бүтээлч арга туршлага бүхий үр нөлөөтэй илтгэл бичсэнгурван багшид батламж гардуулж, дараах байдлаар урамшуулна. Үүнд:

- “Солонгос Монголын багш солилцооны хөтөлбөр”-т хамрагдах эрх
- “Орос Монголын багш солилцооны хөтөлбөр”-т хамрагдах эрх
- “Япон улсад хичээлийн судалгааны туршлага судлах сургалт”-д оролцох эрх

ДӨРӨВ. БУСАД

Эрдэм шинжилгээний хуралд оролцогчдын томилолт болон замын зардлыг орон нутаг, сургууль хариуцна.

ЗУРГАА. ИЛТГЭЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГА

Өнгөрсөн жил зохион байгуулагдсан “Хүүхдийн хөгжил-Хичээлийн судалгаа” сэдэвт анхдугаар хурлын илтгэлүүдийн эмхэтгэлийг www.itpd.mnсайтаас харна уу.

1. Сургуулийн удирдлагын хэлэлцүүлэх илтгэлийн бүтэц-Сургуульд суурисан хичээлийн судалгаа (сургуулийн түвшинд):

ИЛТГЭЛИЙН НЭР:

ХУРААНГҮЙ

- Зорилго
- Судалгааны загвар /арга зүй/ хандлага
- Судалгааны үр дүн
- Практик ач холбогдол
- Шинэлэг тал/санаа
- Түлхүүр үг
- Товч агуулга: 200-250 үг

УДИРТГАЛ

ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭС, СУДАЛГААНЫ ЗАГВАР:

- Сэдвийг сонгосон үндэслэл
- Сонгосон судлагдахуун
- Хамрах хүрээ: Хэддүгээр ангийн хэдэн сургачид хамрагдсан болох, ямар мэргэжлийн хэдэн багш хамрагдсан болох
- Эерэг үр дүн гарахад зарцуулсан хугацаа

ХУГАЦАА:

- Энэхүү судалгааг ямар хугацаанд хийсэн болох

ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

- Гол үйл ажиллагаа /Товч: Сурагчдыг хэрхэн хөгжүүлсэн болох, багшийн арга зүй хэрхэн сайжирсан болох, бие биенээсээ хэрхэн суралцсан болох/

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- Зорилгодоо хүрсэн байдал: Дээрх үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж чадсан эсэхийг нэгтгэн дүгнэх, үр дүнтэй болсон эсэхийг шинжлэх
- Яагаад сайн болсон бэ?
- Бусдад хүргэх туршлага
- Цаашид хөгжүүлэх санал

НОМ ЗҮЙ

2. ЕБ-ЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ИЛТГЭЛИЙН БҮТЭЦ (ТОДОРХОЙ ХИЧЭЭЛЭЭР):

ХИЧЭЭЛИЙН НЭР:

ИЛТГЭЛИЙН НЭР:

ХУРААНГҮЙ:

- Зорилго
- Судалгааны загвар /арга зүй/ хандлага
- Судалгааны үр дүн
- Практик ач холбогдол
- Шинэлэг тал/санаа
- Түлхүүр үг

- Товч агуулга: 200-250 үг

УДИРТГАЛ

ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭС, СУДАЛГААНЫ ЗАГВАР:

- Сэдвийг сонгосон үндэслэл
- Хичээлийн санаа
- Хичээлийн бэлтгэл судалгаа
- Судалгаат хичээл

ХИЧЭЭЛИЙН ӨРНӨЛ ХЭСГИЙН ШИЙДЭЛ (мэдлэг бүтээлгэх)

- Хүүхдээр юуг, яж нээлгэсэн тухай алхмууд (Таамаглал дэвшүүлэх, таамаглалаа шалгах, турших, хэлэлцэх гэх мэт)
- Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд хийсэн зарим сайжруулалт
- Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа: Багшийн асуулт-үндсэн үйл ажиллагаа, тухайн хэсгийн шийдэл-гол санаа
- Хичээлийн хэсэг тус бүрийн шийдлийг хэрэгжүүлсэн байдал: Хичээлийн үеийн протоколын хэсгээс ишлэл хийж, тайлбарлах байдлаар хичээлийн төлөвлөлтийг /хичээлийн эхлэл, өрнөл, төгсгөл /хэрэгжүүлсэн байдлыг танилцуулна.

ДҮГНЭЛТ:

- Яагаад сайн хичээл болсон бэ?
- Бусдад хүргэх туршлага
- Бусад

НОМ ЗҮЙ

3. Мэргэжлийн багийн гишүүд, судлаачдын илтгэлийн бүтэц

- Гарчиг 12pt, Bold, Том үсгээр эхэлж жижиг үсгээр бичнэ.
 - Зохиогчдын нэр, байгууллага, хаяг, 9pt, Bold, Том үсгээр эхэлнэ.
- Товч утга (монгол хэл дээр бичих)
- Түлхүүр үг (заавал биш)
- Удиртгал
- Үндсэн хэсэг
 - Онолын арга зүй
 - Туршилт судалгааны хэсэг
- Үр дүн, дүгнэлт
 - Талархал
 - Ишлэл буюу ном зүй

ДОЛОО. ИЛТГЭЛИЙН БИЧВЭР, ХЭЛБЭРЖҮҮЛЭЛТЭД ТАВИХ ШААРДЛАГА

1. Цаасны хэмжээ ба зاي авах

- Цаасны хэмжээ A4 байх.
- Бичиглэл дээд талаасаа 2.5 см, доод талаасаа 2.5 см, зүүн талаасаа 3 см, баруун талаасаа 2.5 см, , мөр хоорондын зай 1.15 см байх.
- Header (Хуудасны тогой)-9p, *italic*, Тэгш талын зүүн үзүүрт нь хуудасны дугаар, 0,5 inch гэж зай аваад зохиогчийн нэр, цэг тавиад гарчиг бичих. (Хоёроос дээш зохиогчтой бол ... нар гэж товчлох. Гарчиг нь нэг мөрөнд багтахгүй бол гол утгыг гарган хураангуйлах)

2. Хэл

Өгүүллийг MS word программ дээр “Times new roman” фонт ашиглан үсгийн өндөр 11-ээр монгол хэл дээр бичнэ. Abstract (Товч утга) –ийг монгол хэл дээр бичнэ.

3. Илтгэлийн бичиглэлд тавигдах шаардлага

- 3.1. Ишлэлийг дөрвөлжин хаалтанд [1], [7,10-12.14] гэх мэт тэмдэглэнэ.
- 3.2. Тооны аравт, зуутын орны таслалыг цэгээр тэмдэглэнэ.
- 3.3. Томъёог налуугаар бичнэ.
- 3.4. Хаяг-9pt, *italic*
- 3.5. Abstract (Товч утга)-9pt, Үндсэн хэсгийн баруун, зүүн талаас 1 inch (2.54 см) зйтай бичнэ.
- 3.6. Abstract 14 мөрөөс ихгүй байна.
- 3.7. Үндсэн хэсэг-11pt, мөр хоорондын зай single байна.
- 3.8. Ишлэл буюу ном зүй 11pt байна. Ишлэл нь зохиогч, зохиогчийн овог, бүтээлийн нэр, хэвлэсэн газар, он, хуудас гэсэн дараалалтай байна.

Илтгэл №1, №2-ийг дараахи шаардлагын дагуу бэлтгэх.

- Илтгэлийн хураангуйг MS Word программ ашиглан бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлагын дагуу 5-6 нүүрээс илүүгүй бэлтгэх.
- Аман илтгэлийн хугацаа 20 минут байхаар тооцох. Үзүүлэх материалыг MS Power Point, Prezi программын аль нэгийг ашиглан бэлтгэх. Сайжруулсан хичээлийн хөтөлбөр, хичээл ажиглалтын хуудас, хэлэлцүүлгийн протокол, фото зураг, видео бичлэг зэрэг баримтуудыг хавсаргаж болно.

Ханын илтгэлийг дараах шаардлагын дагуу бэлтгэх.

- Илтгэлийн хураангуйг MS Word программ ашиглан бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлагын дагуу 2 нүүрээс илүүгүй бэлтгэж ирүүлэх.
- Илтгэлийг 120:80 см хэмжээтэй фото цаасан дээр хэвлүүлнэ.

НАЙМ. БАГШЛАХУЙН АРГА ЗҮЙН САЙН ТУРШЛАГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ТУХАЙ

- Эрдэм шинжилгээний бага хурлын өмнө илтгэлийн хураангуй хэвлэгдэнэ.
- Эрдэм шинжилгээний хурлын дараа бичвэр ба илтгэл тавигдах шаардлага хангасан илтгэлүүдээр хурлын илтгэлийн эмхэтгэл гаргана.
- Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн сайн туршлага бүхий үр нөлөөтэй илтгэлийг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн www.itpd.mn веб сайт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн [“www.hicheeliin-sudalgaa.mn”](http://www.hicheeliin-sudalgaa.mn) веб сайтад байршуулна.